



Funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



БАРУУН БҮСИЙН ТӨРИЙН  
ӨМЧИЙН УУГАН ИХ СУРГУУЛЬ

Appendix 4 Minute of joint meeting of Departments curriculum sub-commission, dated 15-May-2020.

Ховд их суруулийн БШТС-ийн Газарзүй-геологи, Хими-биологийн тэнхмийн  
хөтөлбөрийн дэд хорооны хамтарсан хурлын тэмдэглэл

**Хугацаа: 2020 оны 05 сарын 15**

**Хурал ХИС-ийн хичээлийн 1-р байрны 401 тоотод 2020 оны 05 сарын 15ны өдрийн  
13:00 цагт эхэлж 14:00 цагт дуусав.**

**Ирц:** Хуралд тэнхмийн эрхлэгч, дэд профессор Б.Баярхүү, дэд профессор Д.Отгонбаяр,  
доктор Д.Батцэцэг, ахлах багш Э.Амаржаргал, Ч.Аюурзана нар оролцов. Ирц 100% байв.

**Хэлэлцсэн асуудал:**

1. Ирэх хичээлийн жилд ХИС-ийн хэмжээнд 2-р дамжааны оюутнуудын сонгон судлах хичээлд Дэлхий судлал хичээл заах тухай.
2. Газарзүй-экологи хос мэргэжлийн хөтөлбөр дэвшүүлэх тухай
3. INTENSE төслийн хүрээнд боловсруулсан хичээлийн тодорхойлолтын тухай

**Хурлын явц:**

**Б.Баярхүү:** Өнөөдрийн хурлаар дээрх асуудлуудын хүрээнд яригдах танилцуулгуудыг холбогдох багш нар нь танилцуулна уу.

**Э.Амаржаргал:** ХИС-ийн оюутнууд суралцах хугацаандаа сонгон судлах хичээлүүд төлөвлөгөөнд туссан байдаг. Энэ төлөвлөгөөний дагуу ГГТ-ээс Дэлхий судлал хичээлийг заадаг. Энэ хичээл нь жил бүр сонгосон оюутны тоо нь өсөж сонирхон судлах оюутны тоо нэмэгдсэн. Мөн ХИС-д хэрэгжиж буй хөтөлбөрүүд нь ирэх хичээлийн жилд өөр байгаа тул тэр хөтөлбөрүүдийн оюутнуудад тохируулан агуулгын хувьд өөрчилсөн болно.

**Д.Батцэцэг:** Газарзүйн тэнхим нь анх байгуулагдсан цагаасаа Газарзүй-Түүх, Газарзүй-Биологи, Байгаль шинжлэл, Газарзүй- Байгаль шинжлэл, Газарзүйн багш хөтөлбөрүүдээр мэргэжилтэн бэлтгэж ирсэн. Сүүлийн жилүүдэд төгсөөд ажиллаж буй төгсөгчдийн ажлын байр, эрэлт хэрэгцээнд үндэслэн мөн дан Газарзүй хөтөлбөрийн элсэлт буурч байгаатай холбогдуулан өөр мэргэжилтэн хүрээнд хөтөлбөр дэвшүүлж байна. Ирэх хичээлийн жилээс Газарзүй-экологи хөтөлбөрөөр элсэлт авах саналын дагуу хос мэргэжлийн хөтөлбөр боловсруулсан. Ингэхдээ Монгол улсын тэргүүлэх их дээд сургуулиудад байгалийн ухааны багш мэргэжлээр хөтөлбөр хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийсэн болно.

**Д.Отгонбаяр:** 1. Дэлхий судлал хичээлийн агуулгад Дэлхийн улс төрийн газарзүй, тогтвортой хөгжлийн агуулгыг нэмж оруулан өөрчлөх нь зүйтэй болов уу. Учир нь Дэлхий судлал нь мэргэжлийн бус оюутнууд учир тэдгээр оюутнуудын сонирхолыг татаж, цаашид газарзүйн мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд чухал учраас агуулгыг нь газарзүйн шинжлэх ухааны шинэ чиг хандлага руу хандуулах хэрэгтэй гэж бодож байна.

**Ч.Аюурзана:** Газарзүй-Экологи хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд экологийн агуулгыг хэрхэн оруулсан бэ?

**Д.Батцэцэг:** Экологийн агуулгыг ургамлын экологи, амьтны экологи, бичил биетний экологитой холбоотой хичээлүүд орсон. Ингэхдээ БОХТ хөтөлбөрийн төлөвлөгөөг харьцуулан тус тэнхмийн багш нартай хамтран гаргасан. Мөн зуны хээрийн дадлагуудад оруулж өгсөн. Хос хөтөлбөр учраас кредитийн хувьд өндөр байгаа болно. Учир нь хос





мэргэжил. Гэхдээ нэг улиралд судлах хичээлийн тоо, нэг улиралд ногдох кредитийн хэмжээг нь ХИС-ийн журамд заасны дагуу тооцсон.  
**Б.Баярхүү:** ХИС-д хэрэгжиж буй INTENSE төслийн хүрээнд байгалийн ухааны чиглэлийн докторын сургалтын хөтөлбөр боловсруулсан. Эдгээр хөтөлбөрүүд нь зохих загварын дагуу хийгдсэн. Энэ хөтөлбөрүүдийг танилцуулав. Хичээл бүр нь ХИС-ийн докторын сургалтын төлөвлөгөөнд 2 кр тусгагдсан байдаг. Багш хичээлээ дуу, дүрсжүүлсэн. Эдгээр хичээлүүдийн төлөвлөгөө нь магистр, докторын сургалтын хөтөлбөрт байгаа хичээлүүдийг шинэчилсэн.

**Шийдвэрлэсэн нь:**

Дэлхий судлал хичээлийн агуулгад Дэлхийн улс төр, тогтвортой хөгжил, экосистемийн үйлчилгээний агуулгыг оруулан өөрчлөх  
Газарзүй-экологийн багш хос мэргэжлээр Багш байгалийн ухаан индексийн дор хөтөлбөр дэвшүүлэн дараагийн хичээлийн жилд ерөнхий хөтөлбөрийн хороонд танилцуулах, ХИС-ийн захиргаа, эрдмийн зөвлөлд танилцуулан 2021-2022 оны хичээлийн жилээс элсэлт авах бэлтгэлийг ханган INTENSE төслийн хүрээнд боловсруулсан хичээлүүдийн төлөвлөгөөг дэмжиж хөтөлбөрийн ерөнхий хорооны комисст танилцуулах

Тэмдэглэл хөтөлсөн:

Хөтөлбөрийн дэд хорооны н.б.д

ахлах багш Э.Амаржаргал

Хянасан:

Хөтөлбөрийн дэд хорооны ахлагч

дэд профессор Д.Дарьханд



Minutes of joint meeting of curriculum sub-commission for departments  
of Geography-geology and Chemistry-biology,  
School of natural science and technology, Khovd state university

15 of May 2020

**Duration:** The meeting was started at 13:00 and ended at 14:00 on 15 of May 2020

**Location:** Room 411. Building 1, Khovd state university

**Attendance:** Head of Geography-geology department sub-commission B.Bayarkhuu-associate professor, Head of Chemistry-biology department sub-commission D.Darikhand –associate professor, associate professor D.Otgonbayar, senior lecturer- D.Battsetseg, senior lecturer E.Amarjargal, senior lecturer Ch.Ayurzana. Attendance at the curriculum sub commission was 100%.

**Discussion topic:**

1. To teach elective course "Earth science" for 2nd year students at the Khovd state in the next academic year.
2. To propose a dual professional program of geography and ecology
3. About the course description developed within the INTENSE project

**Meeting procedure:**

Discussion-1 introduced by -senior lecturer E. Amarjargal


Discussion-2 introduced by- doctor (Ph.D) D.Battsetseg


Discussion-3 Coordinator of INTENSE project associate professor B.Bayarkhuu introduced about syllabuses and curriculum improvement principle which was developed as part of the INTENSE project to the members of departments curriculum sib-commission. Syllabuses:

- Land use and pasture management
- Plant chemistry
- Climatology-glacialogy
- Research methodology of science

**Decision:**

According curriculum assessment the syllabuses majority of members of the curriculum sub-commission agree to accept syllabuses and needs to introduce to the University curriculum commission.

Written by  E.Amarjargal (Secretary of the department curriculum sub commission)

Reviewed by  D.Darikand (Head of the department curriculum sub commission)



Funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



БАРУУН БҮСИЙН ТӨРИЙН  
ӨМЧИЙН УУГАН ИХ СУРГУУЛЬ

Appendix 5 Minute meeting of Curriculum commission, dated 11-June-2020

## ХОВД ИХ СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 10 сарын 01

**Хугацаа:** Хурал ХИС-ийн хичээлийн 1-р байрны 313 тоотод 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 13 цагт эхэлж 15 цагт дуусав.

**Ирц:** ХИС-ийн хөтөлбөрийн хорооны дарга доктор дэд профессор Д.Өнөрнасан, ТДСА-ны менежер доктор Ц.Оюун, тэнхмийн эрхлэгч, дэд профессор Б.Баярхүү, Хими-биологийн тэнхмийн эрхлэгч дэд профессор Д.Дарьханд, доктор Н.Тэгшжаргал, СНА-ны хөтөлбөр хариуцсан менежер доктор Б.Алтантуяа, доктор Д.Батцэцэг нар оролцов.

### Хэлэлцсэн асуудал:

- Байгалийн ухааны чиглэлийн докторын сургалт эрхэлж буй тэнхмүүд сургалтын төлөвлөгөөгөө нэгтгэх боломж
- INTENSE төслийн хүрээнд боловсруулсан хичээлүүдийн тодорхойлолт хэлэлцэх.

### Хурлын явц:

**Б.Баярхүү:** 1. ХИС-д байгалийн ухааны чиглэлээр Газарзүй, Биологи, Химийн докторын сургалтын хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа. Цаашид энэ хөтөлбөрүүдийг сайжруулах, салбар дундын хөтөлбөр болгох боломж байгаа талаар ярилцъя. Энд суралцаж доктор хамгаалах төгсөгчид маань УБ хотод тухайн чиглэл чиглэлээрээ химийн, газарзүйн, биологийн хамгаалуулах зөвлөлд хамгаалдаг. Харин бид эндээ салбар дундын хөтөлбөртэй болсоноор нийгэмд эрэлт хэрэгцээтэй байгаа ахьсан түвшний сургалтын чиглэл нэмэгдэж сургалт явуулах боломжтой юм. ХИС-д хэрэгжиж буй Европын холбооны ERASMUS төслийн санхүүжилттэй INTENSE төслийн хүрээнд хүрээлэн буй орчны менежмент технологийн мэргэжлийн ахьсан түвшний сургалтын хөтөлбөрийг сайжруулах явдал юм. Иймд манай сургуулийн хүрээнд одоо хэрэгжиж байгаа байгалийн ухааны ахьсан түвшний сургалтын хөтөлбөрүүдээ нэгтгэх боломж байгаа юм. Нэгтгэх гэдэг нь сургалтын төлөвлөгөөнүүддээ дүн шинжилгээ хийж Сургалтын төлөвлөгөөн дэхь хичээлийн агуулга нэр нэршилийг сайжруулах Ахьсан түвшний шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн 2 зам байна.

2.Энэ төслийн хүрээнд ММЗ, Хими-биологи, газарзүй-геологийн тэнхмийн багш нарын хамтран боловсруулсан хичээлийн хөтөлбөр тодорхойлолтууд бий. Энэ хөтөлбөрүүдэд судлах хичээлүүд нь суралцагчдын судалгааны чиглэлийг хамарсан байдаг. Дараахь хөтөлбөр тодорхойлолтууд нь Газар ашиглалт, бэлчээрийн менежмент /ХБТ ба ГГТ/ Ургамлын биохими /ХБТ/ Цаг уур, мөстлөг судлал /ГГТ/ Шинжлэх ухааны судалгааны аргазүй / ММЗ, ХБТ, ГГТ/ хичээлийн тодорхойлолтууд боловсруулсан.

**Д.Өнөрнасан:** Хөтөлбөрийн хорооноос сургалтын төлөвлөгөөний шинэчлэл хийхээр төлөвлөж судалгаа хийгдэж байна. Цаашдаа хөтөлбөр төлөвлөгөөндөө үр дүнд суурилсан сургалтын зарчмуудыг тусгах юм. Байгалийн ухааны тэнхмийн багш нар хамтран хичээл боловсруулсанаар байгалийн ухааны чиглэлийн ахьсан түвшний сургалтуудын уялдаа сайжирна. Сургалтын төлөвлөгөөний шинэчлэл эхлэхэд энэ талаараа сайн судалж тусгах ньзүйтэй юм.

**Д.Дарьханд:** Шинээр ахьсан түвшний хөтөлбөр нээх талаар эртнээс бэлтгэж судалгаа хийх хэрэгтэй. МУИС-д хэрэгжиж байгаа хөтөлбөрөөс ялгарах ялгааг тодруулж судлана. Яамнаас одоогоор шинэ хөтөлбөр нээх талаар хүсэлт авахгүй байгаа тул бид эндээ бэлтгэлээ сайн хийх хэрэгтэй.

**Б.Алтантуяа:** Ахьсан түвшний шинэ хөтөлбөр боловсуулахдаа хими, физик, биологийн шинжлэх ухааны суурь хичээлүүдийг тусгах одоо байгаа хөтөлбөрөөс хичээлүүд тусгах





Funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



БАРУУН БҮСИЙН ТӨРИЙН  
ӨМЧИЙН УУГАН ИХ СУРГУУЛЬ




хэрэгтэй. Дээрх боловсруулсан хичээлүүдийн хөтөлбөрийг ХИС-ийн хөтөлбөрийн хорооны үнэлгээний дагуу үнэлье.

**Шийдвэрлэсэн нь:**

Хөтөлбөрийн хорооны хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар ахьсан түвшний шинэ хөтөлбөр боловсруулах ажлыг дэмжиж боловсруулсан хичээлийн хөтөлбөр тодорхойлолтыг сайшаав.

Тэмдэглэл хөтөлсөн:

Хөтөлбөрийн дэд хорооны н.б.д  доктор Б.Алтантуяа

Хянасан:

Хөтөлбөрийн хорооны дарга  дэд профессор Д.Өнөрнасан





Minute meeting of curriculum commission for  
Khovd state university

01<sup>st</sup> of October 2020

**Duration:** The meeting was started at 13:00 and ended at 15:00 on 01<sup>st</sup> of October 2020

**Location:** Room 313. Building 1, Khovd state university.

**Attendance:** Head of curriculum commission, associate professor D.Unurnasan, manager of graduate school, doctor Ts.Oyun, Geography-geology department B.Bayarkhuu-associate professor, Head of Chemistry-biology department sub-commission D.Darikhand –associate professor, senior lecturer N.Tegshjargal, D.Battsetseg, curriculum manager of Academic affairs, doctor B.Altantuya. Attendance at the curriculum commission was 100%.

**Discussion topic**

1. Opportunities for consolidate PhD programs of natural science departments such as Geography, Biology and chemistry doctoral programs
2. Discuss the definition of syllabuses under the INTENSE project.

**Meeting procedure:**

B.Bayarkhuu: The School of Science and Technology has doctoral programs in Geography, Biology and Chemistry. Possibility of improving these programs in the future and turning them into cross-sectoral programs. After studying here, our doctoral graduates defend their dissertations in Ulaanbaatar in the field of chemical, geographical and biological depending commission. However, by having an interdisciplinary program here, it is possible to increase the level of graduate training that is in demand in society. The INTENSE project, funded by the European Union's ERASMUS project at the Khovd state University aims to improve the advanced training program in environmental management technology. Therefore, there is an opportunity to integrate the current advanced science curricula within our school. Consolidation means analyzing current training programs.


Within the framework of this project, there are course syllabuses developed jointly by staffs of Mathematic-IT, Chemistry-Biology and Geography-Geology departments. The study subjects in these programs cover the student's research area. The following syllabuses are:


- Land use and pasture management
- Plant Biochemistry
- Meteorology and Glaciology
- Research methodology of science

B.Altantuya: The development of a new advanced curriculum should include lessons from existing curricula that incorporate basic chemistry, physics, and biological sciences. The syllabuses developed above will be assessed according to the assessment of the Khovd state university Curriculum Commission.

**Decision:**

According curriculum assessment the syllabuses majority of members of the curriculum commission agree to accept above discussed syllabuses.

Written by  B.Altantuya (Secretary of the curriculum commission)

Reviewed by  D.Unurnasan (Head of curriculum commission)

